

улсыг урьсан бөгөөд 7 дугаар сард Туркийн ерөнхий сайдын зөвлөх Култекин Озкан тэргүүтэй төлөөлөгчид манайд айлчилж, уг асуудлаар манай холбогдох хүмүүстэй санал солилцов.

1992 оны 6 дугаар сард туркийн тал хүмүүнлэгийн тусламж болгон 26 тн. хүнсний барааг 2 онгоцоор Улаанбаатарт хүргэж ирсэн.

Манай улсын үндэсний баяр-ардын хувьсгалын 71 жилийн ойн баяр наадамд Туркийн ерөнхий сайдын ахлах зөвлөх Н. Зейбек (хуучин Соёлын яамны сайд байсан) тэргүүтэй төлөөлөгчид ирж оролцсон бөгөөд тэрээр манай удирдах хүмүүстэй уулзах үеэр ярилцаж тохирсоны дагуу 1992 оны 10 сараас манай 18 оюутан Туркт сурч эхэлсэн бөгөөд 1993 оны хичээлийн жилд мөн 20 оюутан авахаар болсон.

Мөн Монголын мусульманы нийгэмлэгийн төлөөлөгчид 1991 оны эхээр Туркт айлчилж, Шашны хэрэг эрхлэх Яам, Соёлын яамны сайд нартай нь болон бусад хүмүүстэй уулзаж санал солилцсон. Тус нийгэмлэгийн шугамаар Туркт 1991 оноос хойш шашны болон бусад сургуульд 150 орчим хүүхэд төрөл бүрийн мэргэжлээр сурч байна.

Туркийн Төлөөлөгчид 1992 оны 9 дүгээр сард Монголд ирж, «Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих тухай хэлэлцээр»-ийн төслийг 1993 оны 6 дугаар сард манай төлөөлөгчид Туркт айлчилж, «Давхар татвар ногдуулахаас зайлсхийх тухай хэлэлцээр» ийн төслийг тус тус үзэглэв. Харин Туркийн Засгийн газрын Хэмжээний эдийн засгийн төлөөлөгчид 1993 оны 10 дугаар сард Монголд айлчилж манай холбогдох яам газрын удирдах хүмүүстэй уулзаж, хамтын ажиллагаагаа хөгжүүлэх талаар санал солилцсон байна. Мөн айлчлалын үеэр «Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх тухай» протоколд гарын үсэг зуржээ.

Ийнхүү манай улстай харилцаагаа өргөтгөх туркийн сонирхол өсч байгаа болон богино хугацаанд эдийн засаг нь үсрэнгүй хөгжсөн туршлага зэргийг нь харгалзна Турктэй Монгол улс бүх талын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэн хөгжүүлэхийн төлөө байна.

**МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ**

**КОЛЛЕЖ де ФРАНС**

Ц. Эрдэнэчимэг\*

Франц улс дэлхийн соёлт орны нэг билээ. Дэлхийн шинжлэх ухаан, соёл, урлагт үлэмж хувь нэмэр оруулсан гарамгай хүмүүс, шинжлэх ухаан, соёл, урлагийн уурхай болсон байгууллага Францад олон бий. Тэдгээрийн дотор олон зуун жилийн түүхтэй бөгөөд одоо ч үйл ажиллагаа нь улам бүр өргөжин тэлсээр байгаа байгууллага цөөнгүй байна. Шинжлэх ухааны тийм томоохон байгууллагын нэг нь Коллеж де Франс юм. Парис хотын төв хэсэгт эртний гоёмсог байшинд байрладаг энэ байгууллага нь Франц улсын эрдэм шинжилгээний газруудад хийгддэг суурь судалгааг удирдан зохицуулахын зэрэгцээ их сургуулийн дараах сургалтыг явуулах үүрэгтэй ажээ.

Төрийн ивээлд байдаг бөгөөд Боловсролын яамны сайд шууд хариуцдаг энэхүү Коллеж де Франс нь 1530 онд Францын ван I Франсуагийн санаачилгаар байгуулагдаж, анхандаа «Вангийн Коллеж» гэсэн нэртэй байгаад 1870 оноос «Коллеж де Франс» гэж нэрлэгдэх болсон байна.

Коллеж де Франсыг энэ байгууллагын ерөнхийлөгч толгойлох бөгөөд түүнийг гурван жилийн хугацаагаар сонгодог байна. Бүрэн эр-

\* ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

хийнх нь хугацаа дуусахаас өмнө халах, солих эрхийг зөвхөн улсын Ерөнхийлөгч л эдэлдэг ажээ.

Шинжлэх ухааныг удирдан зохицуулах болон сургалтын ажлыг Коллежийн Ассамблей гүйцэтгэнэ.

Энэхүү Ассамблей нь 52 гишүүнээс бүрддэг. Тэд нар нь шинжлэх ухааны гол гол салбарыг төлөөлсөн нэрт эрдэмтэд байдаг. Ассамблейн гишүүнд зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийсээр байгаа эрдэмтэд сонгогдоно. Тэгэхдээ заавал эрдэмийн зэрэг, цолтой хүн байх албагүй. Гишүүнээр гол төлөв Францын Шинжлэх ухааны академи, Эрдэм шинжилгээний үндэсний төв (Centre national de la recherche scientifique), Нийгмийн ухааны дээд сургууль (Ecole des hautes etudes en sciences sociales), Эрүүл мэнд, анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний институт (Institut nationale de la santé et de la recherche médicale), Атомын энергийн комисс (Comissariat pour l'energie atomique), Пастерийн институт (Institut Pasteur) -ээс нэр дэвшүүлдэг ажээ.

Ассамблей жилд 2 удаа хуралдаж, Коллежоос явуулах эрдэм шинжилгээний болон сургалтын ажлын чиглэлийг тогтоож, багш нэг бүрийн заах хичээлийн программыг хэлэлцэж шийдвэр гаргадаг. Олонхийн санал буюу Ерөнхийлөгчийн хүсэлтээр Онцгой чуулганыг ч хуралдуулж болдог байна. Коллеж нь шийдвэр гаргах талаар бие даасан эрхтэй бөгөөд Боловсролын яам түүний гаргасан шийдвэрийг бараг л өөрчилдөггүй байна.

Ассамблейн гишүүд өөрсдийнхөө мэргэжлийн дагуу нэг нэг тэнхимийг удирддаг ба профессор цолтой байна. Коллежийн профессор цолыг улсын Ерөнхийлөгчийн шийдвэрээр олгоно.

Гишүүн сонгох ажлыг 2 үе шаттай явуулдаг ажээ. Эхний шатанд нэр дэвшигдсэн хүмүүс (ихэвчлэн 2-3 хүн) -ийн боловсруулсан эрдэм шинжилгээ-сургалтын ажлын төслүүдийн талаар нууц санал хураалт явуулна. Эдгээр төслүүдийг Ассамблейн бусад гишүүдэд урьдчилан тарааж танилцуулсан байдаг. Төслийг ийнхүү сонгох нь тухайн тэнхимийн чиглэлийг тогтооно гэсэн үг юм.

Хоёр дахь шатанд сонгон авсан төсөлд зохицуулан кандидатурын талаар мөн нууц санал хурааж гишүүнийг шалгаруулж сонгодог байна.

Ассамблейн гишүүн-профессорууд тус бүрдээ нэг тэнхим удирддаг учир нийт 52 тэнхим ажиллана. Тэдгээрийн 49 тэнхимийнх нь удирдагч орон тооных, 3-ынх нь орон тооны бус юм. Дурдсан 49 тэнхимийн 20 нь байгалийн ухааны, 29 нь нийгмийн ухааны чиглэлтэй. Байгалийн ухааны тэнхимүүд нь дотроо математик, физик, хими, биологи, анагаах ухаан гэсэн салбаруудад хуваагдах ба нийгмийн ухааны тэнхимүүд нь:

- Философи, социологи, эдийн засаг;
- эртний түүх, археологи;
- шашны түүх;
- соёлын түүх;
- хэл зүй, уран зохиол;
- урлагийн салбаруудыг хамрана.

Үлдсэн 3 тэнхимийн хоёрыг гадаадын 2 эрдэмтэнд нөөцөлж үлдээдэг ба тэд нь голцуу 2 сарын хугацаагаар ирж ажилладаг аж. Гурав дахь тэнхимийг Европын орны нэг эрдэмтэнг урьж ажиллуулахад зориулж 1989 оноос бий болгосон ба тэр эрдэмтэн нь нэг жилийн хугацаагаар ирж ажиллана. Түүнчлэн 1992 онд дөрөв дэх тэнхимийг «Олон улсын тэнхим» нэртэйгээр нээжээ. Уг тэнхимд гадаадын ямар ч орны эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж болох аж.

Гишүүд тэтгэвэр тогтоолгож чөлөөнд гарах хүртлээ, өөрөөр хэлбэл 70 нас хүртлээ Коллежид ажиллаж, Ассамблейн гишүүн хэвээр байж болдог байна. Аль нэгэн гишүүн чөлөөнд гараад эрдэм шинжилгээний ажил эрхлэхээ боливол тэр тухайгаа Коллежийн хэвлэлээр дамжуулан нийтэд мэдэгдэж, гишүүнийхээ байрыг өөрөө чөлөөлж өгөх ёстой. Тэгсэн тохиолдолд түүний оронд өөр хүний нэрийг дэвшүүлэх ажил эхэлнэ. Ассамблей энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээс хойш нэг сарын дараа хуралдаж ямар мэргэжил, эрдэм шинжилгээний ямар чиглэлээр гишүүн нөхөн сонгох тухай асуудлыг авч хэлэлцдэг байна.

Коллеж де Франс-т их сургуулийн дараах боловсрол олох хүсэлтэй хэн боловч ирж суралцаж болдог байна. Тийм хүмүүсийг оюутны журмаар биш, чөлөөт сонсогчдын журмаар элсүүлж авдаг тул сургалтыг дамжаа хэлбэрээр үнэ төлбөргүй явуулдаг ба зохих дамжаа дүүргэсэн хүнээс шалгалт шүүлэг авдаггүй, диплом олгодоггүй байна. Энэ нь Коллеж де Франсын нэг гол онцлог юм. Сургалтыг их, дээд сургуулийнх шиг хөтөлбөрөөр явуулдаггүй, зөвхөн эрдэм шинжилгээний тодорхой чиглэл, сэдвээр явуулдаг байна.

Коллеж нь мөн судалгаа, шинжилгээний ажил хийх, дур сонирхолтой, авьяастай хүмүүсийг авч өөрийн олон тооны лабораториуддаа дадлага хийлгэдэг байна.

Коллежийн гишүүд, тэнхимүүдийг үйлчилдэг томоохон номын сан ажилладаг бөгөөд түүнийг Коллежийн Ерөнхийлөгч шууд удирдана.

Дурдсанаас үзэхэд Коллеж де Франс нь Франц улсын эрдэм шинжилгээний байгууллагууд дотор чухал байр суурийг эзэлдэг ба онцгой эрх эдэлдэг ажээ.

## МОНГОЛ, СОЛОНГОСЫН ЭРДЭМТДИЙН II ХУРАЛДААНЫ ТУХАЙД

### **Б. Лхагваа**

ШУА-ийн Дорно дахин, олон улс судлалын хүрээлэн, Бүгд Найрамдах Солонгос улсын (БНСУ) Соганы Их Сургуулийн Зүүн Азийн хүрээлэнгийн хамтын ажиллагааны хүрээнд 1993 оны 9-р сарын 9—11-нд Сеул хотноо «Зүүн хойт Ази: Монгол-БНСУ-ын харилцаа» сэдэвт эрдэм шинжилгээний II хурал болов. Хуралд Соганы Их Сургуулийн профессор Ким Су Ён «Монголын эдийн засгийн шинэчлэлт, гадаад худалдааны хөгжлийн хэтийн төлөв», ДДОУС-ын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд доктор Г. Хашбат «Зүүн хойт Ази: Хятад-Оросын харилцаа ба түүний Монгол дахь үр дагавар», мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б. Лхагваа «Орчин үе, Монгол-БНСУ-ын харилцаа», Ганвоны Их сургууль, Корегийн Их сургуулийн багш, монгол судлаач, доктор Ким Сен Хо «XIV зууны эцсээрх Солонгос-Монголын харилцаа Зүүн хойт Азийн байдалд нөлөөлсөн нь» сэдэвт илтгэлүүд тавьж хэлэлцүүлэв.

Илтгэлүүдтэй холбогдуулан хоёр орны харилцааны хөгжил, хэтийн төлөвийн талаарх судалгаа шинжилгээний ажил, практик алхмуудын талаар үнэтэй саналууд гарав.

Хуралд БНСУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх «XXI зууны хороо»-ны дарга, Соганы Их сургуулийн профессор, нэрт эрдэмтэн и Сан У, БНСУ-ын Шинжлэх Ухааны Үндэсний Академийн гишүүн, Солонгосын түүхийн шинжлэх ухааны үндэсний хорооны ерөнхийлөгч Чүн Хе Жон, Сеулийн Их Сургуулийн профессор Ким Дон Хо нарын зэрэг эрдэм-